

РУТ

[1]

¹Шүүгчдийн захирч байсан өдрүүдэд тэр нутагт өлсгөлөн болов. Иуда дахь Бетлехемээс нэгэн хүн эхнэр болон хоёр хөвгүүнийхээ хамт Моабын нутаг уруу түр суухаар явав. ²Тэр хүний нэр нь Елимелех бөгөөд эхнэрийнх нь нэрийг Наоми гэдэг байв. Хоёр хөвгүүнийх нь нэрийг Махлон ба Хилион хэмээх бөгөөд тэд Иуда дахь Бетлехемийн ефрат хүмүүс ажээ. Тэд Моабын нутагт орж ирэн, тэндээ үлдэв. ³Тэгтэл Наомийн нөхөр Елимелех нас барж, тэрээр хоёр хөвгүүнтэйгээ үлдэв. ⁴Тэд өөрсөддөө Моаб эмэгтэйчүүдийг эхнэр болгон авцгаав. Нэгнийх нь нэрийг Орпа, нөгөөгийнх нь нэрийг Рут гэдэг байв. Тэнд тэд арваад жил амьдарчээ. ⁵Тэгтэл Махлон, Хилион хоёр хоёул бас нас барав. Ингэж тэр эмэгтэй хоёр хүүхэд болон нөхрөөсөө хагацав.

⁶ЭЗЭН Өөрийн хүмүүс дээр ирж, хоол хүнс өгч буйг Моабын нутагт сонссон тул тэрээр хоёр бэрийнхээ хамт Моабын нутгаас буцахаар босов. ⁷Тиймээс тэр өөртэйгөө хамт хоёр бэрээ авч, байсан газраа орхин одов. Тэгээд тэд Иудагийн нутаг уруу буцахаар замд гарав. ⁸Наоми хоёр бэрдээ —Явцгаа. Та хоёр өөр өөрийнхөө эхийн гэрт буцагтун. Та нар нас барагсдад хийгээд надад хандсаны чинь адил ЭЗЭН та нарт энэрэнгүй хандах болтугай! ⁹ЭЗЭН та хоёрыг өөрсдийн нөхрийн гэрт амарлингуй байлган соёрхох болтугай хэмээн өгүүлэв. Тэгээд тэр тэднийг үнссэнд тэд дуугаа өндөрсгөн уйлалдав. ¹⁰Тэд түүнд

—Гэвч бид заавал таны ард түмэн уруу тантай хамт буцна гэв. ¹¹Харин Наоми

—Буцагтун, охид минь! Яагаад та нар надтай хамт явах ёстой билээ? Та нарын нөхөр болчихоор хөвгүүд миний хэвлийд одоо хүртэл бий юу? ¹²Буцагтун, охид минь! Яв. Учир нь би нөхөрт гарахад дэндүү хөгшдөнө. Хэрэв би надад найдвар бий хэмээн хэлж, энэ шөнө нөхөрт гарч, бас хөвгүүд төрүүлсэн ч, ¹³тэднийг өстөл нь та нар хүлээх үү? Тэгснээр та нар гэрлэхээс татгалзах уу? Үгүй, охид минь. Яагаад гэвэл энэ нь та нараас илүү надад хүнд байна. Учир нь ЭЗЭНий мутар миний эсрэг байсан юм гэв. ¹⁴Тэд дахин дуугаа өндөрсгөн уйлалдав. Орпа хадам эхийгээ үнсэж, харин Рут түүнд наалдав.

¹⁵Тэгтэл тэр

—Харагтун, бэргэн чинь өөрийн ард түмэн болон өөрийн бурхад уруугаа буцан явлаа. Бэргэнийхээ араас буц гэв. ¹⁶Харин Рут

—Таныг орхиж, таныг дагахаас буцаж эргэхийг надад бүү ятгаач. Учир нь таны явах газар уруу би явна. Таны суух газарт би ч сууна. Таны ард түмэн миний ард түмэн, таны Бурхан миний Бурхан. ¹⁷Таны үхэх газарт би үхнэ. Тэнд би оршуулагдана. Тиймээс хэрэв би үхлээс бусдаар танаас салбал ЭЗЭН намайг хатуу шийтгэх болтугай гэв. ¹⁸Тэр түүнийг өөртэй нь хамт явахаар эрс шийдсэнийг хараад, түүнд дахин юу ч өгүүлсэнгүй.

¹⁹Тэгээд тэд хоёулаа Бетлехемд хүрч иртлээ явав. Тэднийг Бетлехемд иртэл бүх хотынхон тэднээс болж хөл үймээн болон, эмэгтэйчүүд нь

—Энэ чинь Наоми мөн үү? гэлцэв. ²⁰Тэрээр тэдэнд

—Намайг Наоми гэж битгий дууд. Учир нь Төгс хүчит Нэгэн надад хэрцгий хандсан тул намайг Мара хэмээн дууд. ²¹Би дүүрэн гарч явсан боловч, ЭЗЭН намайг хоосон буцааж авчрав. Нэгэнт ЭЗЭН миний эсрэг гэрчилж, Төгс хүчит Нэгэн намайг зовоосон тул та нар юунд намайг Наоми гэж дуудна вэ? гэлээ.

²²Тэгээд Моабын нутгаас эргэж ирсэн Наоми өөрийн бэр Моаб эмэгтэй Руттай ирэв. Тэд арвай хураалтын эхэн үед Бетлехемд ирэв.

[2]

¹Наомид нөхрийнх нь хамаатан болох их баян хүн байжээ. Тэр хүн Елимелехийн ургийнх бөгөөд нэрийг нь Боаз гэдэг байв. ²Моаб эмэгтэй Рут Наомид

—Намайг тариан талбай уруу явуулаач. Би тааллыг нь олж болох нэгний араас явж, хаягдсан тариан түрүүг түүе гэхэд тэр түүнд

—Охин минь, яв! гэж хэлэв. ³Тийнхүү тэр явж, тариа хадагчдын араас тариан талбайд хаягдсан түрүүг түүв. Тэрээр санаандгүй Елимелехийн ургийн Боазын тариан талбайн хэсэг дээр ирчихсэн ажээ. ⁴Харагтун, Боаз Бетлехемээс ирж, тариа хадагчдад

—ЭЗЭН та нартай хамт байх болтугай гэхэд тэд

—ЭЗЭН таныг ивээх болтугай хэмээн хариулав. ⁵Тэгээд Боаз тариа хадагчдыг хариуцсан зарцдаа

—Энэ хэний бүсгүй вэ? гэв. ⁶Тариа хадагчдыг хариуцсан зарц

—Тэр бол Моабын нутгаас Наомитай хамт буцаж ирсэн Моаб эмэгтэй юм. ⁷Тэр эмэгтэй "Тариа хадагчдын араас юүжилсэн тариан дунд хаягдсан

түрүүг түүж цуглуулахыг надад зөвшөөрөөч" гэж хэлээд ийнхүү ирээд, өглөөнөөс одоо хүртэл байсан. Тэр гэрт түр зуур л сууж байна гэв.

8Тэгээд Боаз Рутад

—Охин минь, анхааралтай сонс. Хаягдсан түрүүг түүх гэж өөр тариан талбай уруу бүү яв. Цаашилбал эндээс битгий яв. Харин эндээ миний шивэгчидтэй үлд. **9**Чи тэдний хадах талбайг харж, араас нь яв. Би зарц нартаа чамд хүрч болохгүй гэж тушаасан. Чи ундаасхаараа ус уух газарт очиж зарц нарын утгасан уснаас уу! гэв. **10**Тэр эмэгтэй нүүрээрээ унан, газарт хүртэл бөхийн, түүнд

—Намайг харь хүн атал, та намайг ажиглаж байдаг. Би яагаад таны тааллыг олсон юм бэ? гэв. **11**Боаз хариулж, түүнд

—Нөхрийгөө нас барсны дараа чиний хадам эхдээ хийсэн бүгдийг, мөн хэрхэн эцэг эх хийгээд төрсөн нутгаа орхин, урьдаас мэдээгүй ард түмэн дээр ирсэн тухай чинь надад бүрэн мэдэгдсэн. **12**ЭЗЭН чиний ажлыг шагнах болтугай. Израилийн Бурхан ЭЗЭНээс ирэх шагнал нь дүүрэн байх болтугай! Түүний далавчин доор чи хоргодох газар хайн иржээ гэв.

13Тэгэхэд тэр

—Хэдийгээр би таны шивэгчин нарын нэг адил биш боловч та намайг тайтгаруулж, шивэгчин надтай үнэхээр элэгсэгээр ярьсан тул эзэн минь таны өмнө би тааллыг тань олов гэж өгүүлэв.

14Хоолны цагт Боаз түүнд

—Нааш ирж, талхнаас идэн, талхаа цуунд дүрэгтүн гэсэнд тэрээр тариа хадагчдын дэргэд суув. Боаз түүнд хуурсан буудай өгсөнд тэр идэж цадаад, заримыг нь үлдээв. **15**Түүнийг хаягдсан түрүүг түүхээр босоход Боаз зарц нартаа тушаан ийн өгүүлэв.

—Тэр юүжилсэн тариан дунд ч хаягдсан түрүүг түүг! Түүнийг бүү доромжлоорой! **16**Мөн түүнд зориулан боодолуудаас зориуд хэсэг түрүүг сугалан, түүнд түүлгэхээр орхи! Түүнийг бүү зэмлэ гэв.

17Ингээд тэрээр үдэш болтол тариан талбайд хаягдсан түрүүг түүв. Дараа нь тэр түүсэн тариагаа цохиход нэг ефа арвайн гурил болов. **18**Тэрээр түүнийг авч, хот уруу явж, хадам эх нь түүний түүснийг нь харав. Тэрээр мөн идэж цадаад үлдээсэн зүйлээ гаргаж хадам эхдээ өгөв. **19**Хадам эх нь түүнд

—Чи өнөөдөр хаана хаягдсан түрүү түүв? Чи хаана ажилласан бэ? Чамайг ажигласан тэр хүн ерөөгдөх болтугай гэв. Ингээд тэр хэнтэй ажилласан тухайгаа хадам эхдээ ярьж,

—Өнөөдөр хамт ажилласан тэр хүний нэрийг Боаз гэдэг хэмээн өгүүлэв.

²⁰Наоми бэрдээ

—Амьд хийгээд үхэгсдээс энэрлээ татан авдаггүй ЭЗЭН тэр хүнийг ивээх болтугай гэж хэлэв. Тэгээд Наоми түүнд дахин

—Тэр хүн бол бидэнд ойрын хүн бөгөөд бас худалдан авах эрх бүхий бидний хамаатны нэгэн юм гэв. ²¹Тэгтэл Моаб эмэгтэй Рут

—Тэр хүн бас "Миний зарц нар бүх ургацыг хурааж дуусах хүртэл тэдний хажуугаас бүү холдогтун" гэж надад хэлсэн гэв. ²²Наоми өөрийн бэр Рутад

—Охин минь, тэр хүний шивэгчидтэй хамт гарах нь сайн юм. Эс тэгвээс өөр тариан талбайд бусад нь чамд хор учруулах вий гэв. ²³Тийнхүү тэрээр арвай болон буудай хураалтыг дуустал хаягдсан түрүүг түүхийн тулд Боазын шивэгчдийн дэргэдээс холдсонгүй. Тэгээд тэр хадам эхтэйгээ хамт амьдрав.

[3]

¹Хадам эх Наоми нь түүнд

—Охин минь, чамайг сайн сайхан байлгахын тулд би чамд амрах газар хайж өгөх биш үү? ²Чиний шивэгчдийнх нь хамт байсан Боаз бол манай хамаатан биш үү? Үзэгтүн, өнөө орой тэр хүн үтрэм дээр арвай шигшинэ.

³Тийм учраас чи биеэ угаан, тослоод, хамгийн сайн хувцсаа өмсөн, доош үтрэм уруу оч! Гэвч тэр хүнийг идэж, ууж дуустал өөрийгөө түүнд бүү таниул. ⁴Түүнийг хэвтэхэд нь чи түүний хэвтэж буй газрыг ажиглаад, явж түүний хөлийг ил гаргаад хэвт! Дараа нь тэр чамд юу хийхийг чинь хэлэх болно гэхэд ⁵тэр түүнд

—Таны хэлсэн бүгдийг би хийнэ гэв.

⁶Ингээд тэрээр үтрэм уруу очиж, хадам эхийнхээ тушаасан бүгдийн дагуу үйлдэв. ⁷Боаз идэж уугаад, зүрх нь хөгжилтэй болоход овоолсон тарианы захад очин хэвтэв. Рут сэмхэн ирж хөлийг нь ил гарган хэвтэв. ⁸Тэгээд шөнө дундын үед тэр хүн цочиж, урагшаа бөхийтөл, нэгэн эмэгтэй хөлд нь хэвтэж байв. ⁹Тэрээр

—Чи хэн бэ? гэхэд тэр

—Би таны шивэгчин Рут байна. Та ойрын хамаатан учир бүтээлгээ шивэгчнийхээ дээгүүр дэлгээч гэв. ¹⁰Тэгтэл тэр

—Охин минь, чамайг ЭЗЭН ивээх болтугай! Чи ямар ч баян, ядуу залуусын араас явсангүй. Ингэснээрээ чиний сүүлчийн энэрэл эхнийхээс чинь илүү дээр болохыг чи харууллаа. ¹¹Одоо охин минь, бүү ай! Чиний

хэлсэн бүгдийг би чиний төлөө хийнэ. Учир нь хотын бүх хүмүүс чамайг онцгой сайн эмэгтэй гэдгийг мэднэ. ¹²Би ойрын хамаатан гэдэг нь үнэн. Гэлээ ч надаас илүү ойрын хамаатан бий. ¹³Энэ шөнө эндээ үлд. Өглөө болоход хэрэв тэр хүн чамайг худалдан авбал сайн. Тэр чамайг худалдан аваг. Харин тэр чамайг худалдан авахыг хүсэхгүй бол би чамайг худалдан авна гэдгээ ЭЗЭНий амьд буйгаар тангараглая. Өглөө болтол хэвт гэв.

¹⁴Тиймээс тэр өглөө болтол түүний хөлд хэвтлээ. Тэгээд Рут хүмүүс бие биенээ танихаас өмнө харанхуйгаар босов. Тэр

—Энэ эмэгтэйг үтрэмд ирснийг мэдэгдэж болохгүй гэв. ¹⁵Тэр дахин

—Өөрт буй нөмрөгөө надад өгөөд барь гэж хэлэв. Тэгээд түүнийг барихад зургаан хэмжүүр арвай хэмжиж, түүнд үүрүүлэв. Ингээд тэр хот уруу явлаа.

¹⁶Тэгээд түүнийг хадам эх дээрээ ирэхэд тэр

—Охин минь, ямар болов? гэхэд мөнөөх хүний өөрт нь юу хийсэн бүгдийг Рут түүнд хэлэв. ¹⁷Тэгээд Рут

—Тэр хүн "Чи хадам эхдээ гар хоосон очиж болохгүй" хэмээн өгүүлээд энэ зургаан хэмжүүр арвайг надад өгөв гэв. ¹⁸Тэгэхэд хадам эх нь

—Охин минь, энэ хэрэг хэрхэн дуусахыг мэдэх хүртэл хүлээ! Учир нь тэр хүн өнөөдөр үүнийг шийдэхээс нааш амрахгүй гэв.

[4]

¹Боаз дааман хаалган дээр очиж, тэнд суухад Боазын өгүүлсэн мөнөөх ойрын хамаатан өнгөрч явах нь харагдав. Тэр түүнд

—Найз минь ирээд энд суу гэв. Тэр ирж суув. ²Тэгээд тэр хотын ахлагчдаас арван хүнийг авчран

—Энд суугтун хэмээн өгүүлсэнд тэд сууцгаав. ³Тэгээд тэр хамгийн ойрын хамаатанд хандан

—Моабын нутгаас буцаж ирсэн Наоми нь бидний ах дүү болох Елимелехийн хэсэг талбайг худалдах ёстой. ⁴Тиймээс би чамд мэдэгдье гэж бодоод "Энд сууж буй хүмүүсийн өмнө болон миний ардуудын ахлагчдын өмнө түүнийг худалдан авагтун. Хэрэв чи үүнийг худалдан авъя гэвэл түүнийг авагтун. Харин үгүй бол надад хэлээрэй! Би мэдье. Учир нь чамаас өөр түүнийг худалдан авах хүн байхгүй. Би чиний дараагийнх юм" хэмээв гэхэд тэр

—Би худалдан авна гэв. ⁵Тэгтэл Боаз

—Чи Наомийн гараас тариалангийн талбайг худалдан авах тэр өдөртөө, мөн нас барагчийн нэрийг түүний өвд өргөхийн тул нас барагчийн бэлэвсэн эхнэр буюу Моаб эмэгтэй Рутыг авах ёстой гэв. ⁶Хамгийн ойрын хамаатан

—Би үүнийг өөртөө худалдан авч чадахгүй. Эс бөгөөс би өөрийнхөө өвийг сүйрүүлнэ. Чи өөртөө үүнийг худалдаж ав. Чи миний худалдан авах эрхийг авч болно. Учир нь би үүнийг худалдан авч чадахгүй гэв.

⁷Израильд урьдын цагт худалдан авах болон газар солилцох талаар ямар нэгэн хэргийг батлахдаа ийм заншилтай байв. Нэг нь шаахайгаа тайлж, нөгөөдөө өгдөг байв. Энэ нь Израильд баталгаатай болгох арга байв. ⁸Тэгээд хамгийн ойрын хамаатан нь Боазд

—Чи өөртөө үүнийг худалдан авагтун хэмээн өгүүлээд шаахайгаа тайлав.

⁹Тэгтэл Боаз ахлагчид хийгээд хамаг ардуудад

—Өнөөдөр би Наомийн гараас Елимелех болон Хилион, Махлон нарт харьяалагдах бүхнийг худалдан авсны гэрч нар нь та нар юм. ¹⁰Бас нас барсан хүний нэрийг өвд нь үлдээхийн тулд би Махлоны бэлэвсэн эхнэр Моаб эмэгтэй Рутыг өөрийн эхнэр болгон авав. Ингэснээр нас барсан хүний нэр нь ах дүү нараасаа болон төрсөн газрынхаа хашаанаас таслагдахгүй юм. Өнөөдөр та нар гэрч нар гэв. ¹¹Хашаан дотор байсан бүх ардууд болон ахлагчид

—Бид гэрч нар мөн. Чиний гэрт орж ирж буй тэр эмэгтэйг ЭЗЭН Израилийн гэрийг босгогч Рахел, Леа хоёрын адил болгох болтугай. Чи Ефратад эд баялаг олж, Бетлехемд алдарших болтугай. ¹²Мөн ЭЗЭНий энэ залуу эмэгтэйгээр өгөх үр удмаар дамжуулан гэр чинь Тамараас Иудад төрүүлсэн Перезийн гэр адил болох болтугай гэв.

¹³Ингээд Боаз Рутыг аван, тэр эмэгтэй түүний эхнэр болов. Боаз түүн уруу орсонд ЭЗЭН түүнд үр тогтоон өглөө. Тэгээд тэр хүү төрүүлэв.

¹⁴Тэгтэл эмэгтэйчүүд Наомид

—Чамайг өнөөдөр худалдан авагчгүйгээр орхиогүй ЭЗЭН магтагдах болтугай! Тэгээд түүний нэр Израильд алдарших болтугай! ¹⁵Тэр нь мөн танд амьдралыг сэргээгч, өндөр насны тань тэтгэгч байх болтугай. Учир нь танд хайртай бэр чинь түүнд хүү төрүүлж өгөв. Рут танд долоон хөвгүүнээс ч илүү дээр билээ гэцгээв. ¹⁶Тэгээд Наоми хүүхдийг авч, өвөр дээрээ хэвтүүлээд түүнийг асрах болов. ¹⁷Хөрш эмэгтэйчүүд нь

—Наомид хүү төрөв хэмээн өгүүлэлдэж, түүнд нэр өгөв. Тэгээд тэд түүнийг Обед хэмээн нэрлэв. Тэр бол Давидын эцэг болох Иессийн эцэг юм.

- ¹⁸Перезийн удам угсаа нь энэ юм. Перезд Хезрон төрсөн билээ.
¹⁹Хезронд Рам, Рамд Амминадаб, ²⁰Амминадабт Нахшон, Нахшонд Салмон,
²¹Салмонд Боаз, Боазд Обед, ²²Обедод Иесси, Иессид Давид төржээ.